



М-СИ-ЭС
ГРУППИЙН
КОМПАНИЙН
НИЙГМИЙН
ХАРИУЦЛАГЫН
ТАЙЛАН

2017



КОМПАНИЙН ТУХАЙ

Товч танилцуулга

Эрхэм зорилго, үнэт зүйлс

КОМПАНИЙН НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА

Компанийн нийгмийн хариуцлагын бодлого

Төсөл, хөтөлбөрүүд

Хэрэглэгчдэд чиглэсэн үйл ажиллагаа

БАЙГАЛЬ ОРЧИН

Байгаль орчны бодлого, баримтлах зарчим

Хийсэн ажил

АЖЛЫН БАЙР

Хүний нөөцийн бодлого

Ажлын байр

Хүний эрх

ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

М-Си-Эс Групп нь өнгөрсөн 24 жилийн хугацаанд бизнесийн алсын хараатай бодлого баримталж, зах зээл дэх байр сууриа бататган тогтвортой далайцтай үйл ажиллагаа явуулж ирсний үр дүнд үндэсний хэмжээний тэргүүлэгч компани болон өргөжин хөгжсөн билээ. Групп нь баялаг бүтээж, үндэсний хэмжээний бүтээн байгуулалтыг цогцлоохдоо хамгийн гол нь улс орны хөгжилд шинэ түрлэг нэмэх, байгаль орчинд ээлтэй, нийгэм, хүмүүст үр өгөөжөө илүүтэй өгөхөд анхаарахын зэрэгцээ үндэсний олон компаниудыг төслийн үйл ажиллагаандаа татан оролцуулж чадавхийг нь нэмэгдүүлэх, ажлын байр олноор бий болгож тогтвортой хадгалах замаар иргэдийн амьжиргааг сайжруулах бодлогыг чухалчлан, ашгийг урьтал болгохгүй зээлийн эргэн төлөгдөх эрсдэлийг өөртөө үүрч ажиллаж ирсэн, хойшид ч түүнийгээ тууштай баримтлах болно.

Бизнесийн чиглэл:

Инженеринг, дэд бүтэц
Уул уурхай
Барилга угсралт, үл хөдлөх хөрөнгө
Мэдээлэл, харилцаа холбоо
Хүнс болон өргөн хэрэглээний бараа,
бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдаа, түгээлт
Нийгэмд чиглэсэн төслүүд

Охин компани:

20 орчим

Ажилтны тоо:

8000

Утас:

11-312625

Хаяг:

М-Си-Эс Холдинг ХХК, Сүхбаатар дүүрэг,
8-р хороо, Сэнтрал Тауэр, 15 давхар,
Улаанбаатар хот 14200

Вэбсайт:

www.mcs.mn



www.facebook.com/MCSGroupOfficial



www.twitter.com/GroupMCS



www.instagram.com/mcsgroupofficial

ЭРХЭМ ЗОРИЛГО: “ДЭЛХИЙН ХӨГЖЛИЙГ МОНГОЛД”

ҮНЭТ ЗҮЙЛС:



МЭРГЭШСЭН ӨНДӨР ЧАДАВХИ

Мэргэжлийн өндөр ур чадвартай, өөрийгөө болон бусдыг байнга хөгжүүлдэг.



БАГИЙН СЭТГЭЛГЭЭ

Харилцан итгэлцэл, хүндлэл, эерэг дулаан харьцааг буй болгон хамт олонтойгоо үр дүнтэй хамтран ажилладаг.



МАНЛАЙЛАЛ

Цаашдын ахиц, хөгжлийн боломжийг олж тодорхойлж, бусдадаа ойлгуулан дэмжлэгийг нь авч, тэднийг урам зоригжуулан, хамтдаа бодит үйл хэрэг болгодог.



ӨӨРИЙМСӨГ ҮЗЭЛ

Ажилдаа болон компанидаа өөриймсөг хандаж, сэтгэл гарган ажилладаг.



САНАЛ САНААЧИЛГА

Хөгжүүлэх, сайжруулах, асуудлыг шийдвэрлэх бүтээлч шийдэл, санал санаачилгыг байнга гаргадаг



ҮНЭНЧ ШУДАРГА ЗАРЧИМ

Монгол Улсын хууль журмыг алхам тутамдаа дээдэлдэг, аливаад үнэнч шударга ханддаг.



ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗАРЧИМ

Нийгэмдээ болон байгаль орчиндоо ээлтэй байхыг эрхэмлэдэг, хөдөлмөрийн аюулгүй байдлыг эн тэргүүнд хангаж ажилладаг.

- Өөрийгөө болон бусдыг хөгжүүлэх нь ажилтан бүрийн эрхэм үүрэг байна.
- Бид ажилтан бүрт хөгжиж, ахиж дэвших орчныг бүрдүүлж, ижил тэгш бололцоо олгоно. Ажилтны өсөж хөгжих, дэвжиж дээшлэх нь тухайн хүний ур чадвар, гүйцэтгэл, оруулж буй хувь нэмэртэй шууд холбоотой байна.
- Бид сайн ажилчин, ажилтан, менежер төдийгүй сайн манлайлагч байхыг эрмэлзэж, бусдадаа үлгэр дууриал үзүүлнэ.
- Бид шинийг сэдэж, аливааг сайжруулах боломжийг цаг ямагт эрэлхийлнэ. Бид шинэ санаа, бүтээлч хандлагыг хөхиүлэн дэмжинэ.
- Бид хамгийн шилдэг шийдэл бүхий бүтээгдэхүүн, үйлчилгээг хэрэглэгчдэд хүргэнэ.
- Өндөр чадавхи, олон ургальч санаа бодол бүхий гишүүдээс бүрдсэн, харилцан итгэлцэл, хүндлэлд суурилсан хамтын зүтгэл нь бидний тогтвортой амжилтын үндэс юм.
- Бид зах зээлийн шударга зарчимд тулгуурлан харилцан биенээ дэмжиж, нөхөж ажилласнаар улам их үр дүн гаргах боломж бололцоогоо нэмэгдүүлнэ.
- Бид ажилдаа эзний сэтгэлээр хандаж, компанийн нэр хүнд, өмч хөрөнгийг хайрлан хамгаална.
- Бид зөв зүйлийг зөв арга замаар хийж, Монгол Улсын хууль тогтоомж, М-Си-Эс Группийн Ёс зүйн дүрмийг өдөр тутам мөрдөж ажиллана.
- Бид ажилтан, түнш, хэрэглэгчтэйгээ харилцахдаа үнэнч шударга зарчмыг баримтална.
- Бид нийгэмдээ болон байгаль орчиндоо ээлтэй байхыг эрхэмлэнэ.
- Бид хөдөлмөрийн аюулгүй байдлыг эн тэргүүнд хангаж ажиллана.

Гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг эх орондоо татаж ажлын байр олноор бий болгон түүнийгээ тогтвортой хадгалах бодлого баримталж иргэдээ байнгын орлоготой, амьжиргааны түвшин нь өсөлттэй байхыг дэмжих нь аливаа компанийн нийгмийн өмнө хүлээх томоохон хариуцлага билээ.

М-Си-Эс Группийн зүгээс эх орон, нийгмийн өмнө зүй ёсоор хүлээх өндөр үүрэг хариуцлага бол татвар, хураамж, шимтгэлээ хуулийн дагуу цаг хугацаанд нь үнэнч шударгаар төлж улсын төсвийн бүрдүүлэлтэд хувь нэмрээ оруулах явдал гэж хэзээд хатуу ойлгож ирсэн бөгөөд энэ бахархалтай үзүүлэлтээр хувийн хэвшлийг олон жил манлайлж байна.

Сүүлийн долоон жилд улсын төсөвт нийт 1,7 их наяд төгрөгийн татвар шимтгэл төвлөрүүлсэн бөгөөд өнгөрөгч 2017 онд 275,6 тэрбум төгрөгийн татвар шимтгэлийг төлсөн нь өмнөх жилээс 50 гаруй тэрбумаар өссөн үзүүлэлт юм.


Түүнчлэн бид Группийн хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтдаа үндэсний компаниудаа бүхий л талаар дэмжин оролцуулж, тэднээс бүтээгдэхүүн үйлчилгээг түлхүү худалдаж авахыг эрхэмлэн ажиллаж ирсэн билээ. М-Си-Эс Группийн компаниуд 2017 онд нийт 545 тэрбум төгрөгийн худалдан авалт хийснээс дотоодын 2255 аж ахуйн нэгж, байгууллага, 580 хувь хүнээс 233 тэрбум төгрөгийн бараа, бүтээгдэхүүн, ажил үйлчилгээг худалдан авсан байна. Түүнчлэн 68,8 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт, 936 тэрбум төгрөгийн борлуулалт хийсэн байна.

Бид, үндэсний компаниуд нь иргэдээ манлайлан дагуулж үсрэнгүй хөгжилд хүрсэн бусад орны туршлагаар Дэлхийн хөгжлийг Монголдоо цогцлоож монголчууд хамтдаа сайн сайхан амьдрахын төлөө зорьж, нийгмийн хариуцлагаа хэрэгжүүлж байна.



1 ЭКСПОРТ

ЭКСПОРТЛОГЧИД /Сүүлийн 5 жилд/



Эх сурвалж: Өдрийн сонин


2 ДОТООДЫН ХУДАЛДАН АВАЛТ

Дотоодын худалдан авалт Сүүлийн таван жилд



Эх сурвалж: Өнөөдөр сонин

3 ТАТВАР



Эх сурвалж: www.itoim.mn

Бид нийгмийн хариуцлагын нэг хэлбэр болон хэрэгждэг хандив, тусламж, ивээн тэтгэлэг нь нийгэм, хүмүүст өгөөжтэй байхыг чухалчилж үздэг бөгөөд оюутан залуусын боловсролыг дэмжих, үндэсний болон орчин үеийн соёл урлаг, багийн спортыг түлхүү хөгжүүлэх, өнчин хүүхдүүд, нийгмийн эмзэг бүлэгт туслах, байгаль орчныг хамгаалах үйлсэд илүүтэй чиглэж байна.

2017 онд М-Си-Эс Группийн компаниуд нийгмийн хариуцлагын чиглэлээр 70 орчим төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлжээ. Тухайлбал, Энержи Реурс компани орон нутгийн тогтвортой хөгжлийг дэмжихэд чиглэсэн төсөл хөтөлбөрүүд, бүтээн байгуулалтад 4,6 тэрбум төгрөг зарцуулжээ. Орон нутагт чадварлаг боловсон хүчнийг тогтвор суурьшилтай ажиллуулахад нь дэмжлэг болгох үүднээс “Цэций” хорооллын 483 сая төгрөгийн үнэ бүхий 6 орон сууцыг сумын “Мөрөөдөл” ерөнхий боловсролын дунд сургуульд үнэ төлбөргүй олгож, Монгол орны онгон дагшин байгаль газар нутаг, баялаг түүх, соёлыг ирээдүй хойч үед таниулах, мөнхлөн үлдээх түүхэн ач холбогдолтой “Бидний цөөхөн Монголчууд” үндэсний төслийн ерөнхий ивээн тэтгэгчээр ажиллаж байна. М-Си-Эс Кока-Кола болон Юнител компаниуд ой хээрийн түймэртэй тэмцэх үйлсэд нэгдэн бүтээгдэхүүн, үйлчилгээ болон 28,5 сая төгрөгийг хандивлажээ.

НИЙГМИЙН САЙН САЙХНЫ ТӨЛӨӨХ ҮЙЛС



2017 онд Монгол Улсын хэмжээнд нийт 119 удаагийн ой хээрийн түймэр гарч, 66,5 мянган га талбай өртсөн билээ. М-Си-Эс Кока-Кола ХХК нийгмийн хариуцлагынхаа хүрээнд гал унтраах ажиллагаанд оролцсон алба хаагчдад зориулан гурван удаагийн тусламжаар нийт 3,5 сая төгрөгийн бүтээгдэхүүн хандивласан байна. Юнител ХХК сансрын холбооны IRIDIUM үйлчилгээ, үүрэн холбооны сүлжээ цацах явуулын станцаа илгээж, ажилтан албан хаагчдад 4 тонн цэвэр ус хүргүүлж, Онцгой байдлын ерөнхий газарт 25 сая төгрөг хандивласан юм. Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх зөвлөмж, сэрэмжлүүлэг мэдээг үүрэн холбооны 1,2 сая хэрэглэгчид, Юнивишн, ДДэшТВ-ийн мэдээллийн сувгаар 434,000 өрхөд хүргэлээ.

Энержи Ресурс ХХК нь олон улсын болон Монгол Улсын холбогдох хууль тогтоомжуудын хүрээнд хариуцлагатай уул уурхайн зарчмуудыг хэрэгжүүлж, нийгмийн сайн сайхан, улс орны эдийн засгийн хөгжилд бодит хувь нэмэр оруулах замаар тогтвортой хөгжлийн бат бэх суурийг бий болгохыг зорьж ирлээ. Энэ утгаараа Олон улсын Стандартын байгууллагаас 2010 оны 10 дугаар сард гаргасан “ISO 26000: Нийгмийн хариуцлагын зөвлөмж” болон Олон Улсын Санхүүгийн Корпораци, Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банк зэрэг байгууллагаас гаргасан удирдамжид үндэслэн Компанийн нийгмийн хариуцлагын бодлогоо боловсруулан батлуулж, хэрэгжүүлж байна. Эдүгээ тус компани нь уул уурхайн салбарын хэмжээнд нийгмийн хариуцлагаа хэрэгжүүлэгч шилдэг компанийн нэгээр зүй ёсоор нэрлэгдэж, оролцогч талуудынхаа итгэлийг хүлээн, улс орны болон орон нутгийн хөгжилд бодит хувь нэмрээ оруулж байна. Орон нутгийн тогтвортой хөгжлийг дэмжих, нийгмийн суурь бүтцүүдийг тогтворжуулахад дэмжлэг үзүүлэх зорилгын хүрээнд дэд бүтэц, эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулах, мэргэшил олгох, соёлынөвийг хамгаалах, жижигдунд бизнесийг дэмжих үндсэн чиглэлүүдээр төсөл, хөтөлбөрүүд хэрэгжүүлдэг. Энержи Ресурс ХХК нь 2017 онд улсын төсөвт татвар, шимтгэл хэлбэрээр 87 тэрбум төгрөг төвлөрүүлсэн бол орон нутгийн тогтвортой хөгжлийг дэмжихэд чиглэсэн төсөл хөтөлбөрүүд, бүтээн байгуулалтад 4,6 тэрбум төгрөг зарцуулжээ.



Өмнөговь аймгийн Засаг даргатай “Хамтын ажиллагааны гэрээ” байгуулж, аймаг, орон нутагтай харилцах харилцаа, хамтын ажиллагаагаа илүү өргөн түвшинд баталгаажууллаа. Тус компани нь орон нутагт уул уурхай, нийгмийн дэд бүтцийг цогцоор шийдэж, ажил эрхлэлт, боловсрол, эрүүл мэнд, байгаль орчны чиглэлээр нийгмийн хариуцлагын цогц бодлоготой ажиллаж ирсэн. Цаашид ч энэ жишгээр хамтын ажиллагаагаа үргэлжлүүлж, Өмнөговь аймаг болон Цогтцэций сумын хөгжилд хувь нэмрээ оруулахыг энэхүү гэрээ баталгаажуулж байгаа юм.



Энержи Ресурс ХХК нь “Амжилтын томъёо” ТББ, Хас банктай хамтран “Орон нутгийн иргэдийн тогтвортой амьжиргааг дэмжих төсөл”-ийн хоёрдугаар үе шатыг эхлүүллээ.

Уг төсөл нь жижиг бизнес эрхлэх сонирхолтой малчид, иргэдэд хүүгүй зээл олгож, төрөл бүрийн бизнесийн сургалтанд хамруулдаг. Ингэснээр нутгийн иргэд өөрсдөө бие даан жижиг бизнес эрхлэх, өрхийн орлогоо нэмэгдүүлэх, цаашлаад сум, орон нутгийн урт хугацааны тогтвортой хөгжилд хувь нэмэр оруулах бодит ач холбогдолтой юм. Төслийн өмнөх шатанд 15 малчин өрх хамрагдаж, жижиг бизнесийн төслөө амжилттай хэрэгжүүлснээр зээлээ хугацаанд нь бүрэн төлж барагдуулсан билээ. 2017 онд уг төслийн цар хүрээг нь нэмэгдүүлж, малчдаас гадна шилжин суурьшсан ажиллагсдын гэр бүлийн гишүүдийг хамруулж, нийт 13 иргэнд 87 сая төгрөгийн хүүгүй зээл олголоо. Эдгээр иргэд 5-10 хүртэлх сая төгрөгийн зээлийн санхүүжилтээ мал аж ахуй, газар тариалан, гоо сайхны худалдаа эрхлэх, нүдний эмнэлгийн тоног төхөөрөмж худалдаж авах, хоолны газрын тохижилт хийх, тоглоомын газар байгуулах, хоолны газар, оёдлын цех ажиллуулах зэргээр бизнесээ өргөтгөх болон аж ахуй шинээр нээхэд зарцуулжээ.



Энержи Ресурс ХХК нь “Сайн хөрш” хөтөлбөрийн хүрээнд орон нутгийн оролцогч талуудтай тогтмол хамтран ажилласаар ирсэн.

Сар шинийн баярыг угтан сумдын Ахмадын хороодтой хамтран нутгийн өндөр настнуудад бэлэг гардуулж хүндэтгэл үзүүлсэн байна. Тухайлбал, Цогтцэций, Ханбогд, Баян-Овоо, Ханхонгор сумдын 70-аас дээш насны 400 орчим ахмадыг хүлээн авч гарын бэлэг гардуулжээ. Мөн говь нутгаар өвөлжилт хүндэрч, зуд болсонтой холбогдуулан Ханбогд, Баян-Овоо, Ханхонгор, Цогтцэций, Манлай, Номгон сумдын малчдад өвс, тэжээлийн тусламж үзүүллээ. 2017 онд 8000 боодол өвс, 1650 уут хивэг тэжээл тараасан байна. Энержи Ресурсын хамт олон жил бүрийн өвөл, хавар энэхүү тусламжийн ажлаа зохион байгуулж ирсэн уламжлалтай юм.



Энержи Ресурс ХХК нь орон нутгийн иргэдийн газар тариалан эрхлэлтийг дэмжих “Ойн зурвас” төсөл хэрэгжүүлж, газрын хөрс боловсруулалт, үрслэг бойжуулах, зуны арчилгаа, хортон шавьжнаас хамгаалах, зэрлэг ургамал устгах сургалт явуулж үүнд 30 гаруй иргэдийг хамруулав. Төслийн хүрээнд 10 га талбайн тариалалтын усжуулалтын систем, харуул хамгаалалтыг шийдвэрлэсэн. Тайлант онд ойн зурвасын 4 га талбайд 60 гаруй өрх хүнсний ногоо тарьж, 18 нэр төрлийн 13,8 тонн төмс, ногоо хураан авчээ.

ХҮҮХДИЙН САЙН САЙХНЫ ТӨЛӨӨХ ҮЙЛС




М-Си-Эс Холдинг компанийн ажиллагсад санаачлан Группийн нийт хамт олонд хандан уриалснаар эцэг эхдээ гологдсон, аав ээж нь архины хамааралтай болсон, амьдралын түвшин доогуур олон бяцхан хүүхдийг орон байр, хоолоор хангаж харж ханддаг М.Сарнай бүсгүйд асрамжийн байр барьж өгөх “Нэг хүн-нэг тоосго аян”-д нэгдэн цалингаасаа 2,8 сая төгрөгийн хандив өргөжээ.



М-Си-Эс Кока-Кола ХХК нь 2005 оноос “Бадамлянхуа” асрамжийн төвд амьдарч буй хүүхдүүдийн амьдрах орчин, сурч боловсрох нөхцөлийг сайжруулах үйлсэд зориулан жил бүр 20,000 ам.доллар хандивлаж ирсэн. Мөн Дархан хот дахь “Нарны хүүхдүүд”, Эрдэнэт хот дахь “Энэрэл” асрамжийн төвүүдийн үйл ажиллагааг

2012 оноос дэмжин ажилладаг. Дээрх асрамжийн төвүүдэд амьдардаг хүүхдүүдэд Олон улсын Хүүхдийн эрхийг хамгаалах өдөр, Шинэ жилийн баяраар жил бүр бэлэг хүргүүлдэг уламжлалтай. Мөн тайлантонд нийслэлийн захын дүүргүүдэд амьдардаг 600 гаруй хүүхдэд Шинэ жилийн баяраар бэлэг өгчээ.



М-Си-Эс Эстэйтс ХХК нь тархины саажилттай хүүхдүүдийн эцэг эхчүүд нэгдэн байгуулсан “Ээлтэй ертөнц” ТББ-ын чихмэл тоглоом үйлдвэрлэх үйл ажиллагааг өргөтгөх, цаашлаад “Тархины саажилтын төв” байгуулах үйлсийг нь дэмжин Вива Сити хороололд байрлах 123 үйлчилгээний талбайг тухайн үйлдвэрлэлийн зориулалтаар хоёр жилийн хугацаанд үнэ төлбөргүй түрээслүүлсэн. Түүнчлэн Будда Виста, Белла Виста, АСЕМ Вилла хотхоны оршин суугчдын дунд уран зураг дуудлагаар худалдаалах хандивын үйл ажиллагааг зохион байгуулж, цугларсан 16 сая төгрөгөөр үйлдвэрийн тоног төхөөрөмж худалдан авч “Ээлтэй Ертөнц” ТББ-д хүлээлгэн өгчээ. Ингэснээр тус ТББ-ын чихмэл тоглоом үйлдвэрлэх гар ажиллагаа механикжиж сацуу бүтээгдэхүүний нэр төрөл эрс нэмэгджээ. Тус хамт олон Вива Сити хороолол дахь “Ээлтэй Ертөнц ТББ”-ын байрны засварт биечлэн тусалцгаасан байна.



М-Си-Эс Эстэйтс ХХК нь “Ахиллис Монгол” олон улсын байгууллагаас зохион байгуулсан хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, багачуудын гүйлтийн тэмцээнийг ивээн тэтгэжээ. “Багачуудын гүйлт 2017” тэмцээнд нийслэлийн 25, 29, 55, 63, 70, 116 дугаар тусгай сургуулиудын 500 гаруй хүүхэд оролцсон юм. Тус хамт олон хүүхдийн хүчирхийллийн эсрэг “Нүдээ нээ” сайн үйлсийн аяны уриалгад нэгдсэн юм.



Олон улсын Хүүхдийн эрхийг хамгаалах өдөр Ухаа худагийн уурхайчин залуус “Энержи Ресурсын багачууд” өдөрлөг зохион байгууллаа. Баярын үйл ажиллагаанд 400 орчим хүүхэд оролцсон бөгөөд компанийн ажиллагсдын зүгээс “Минионы адал

явдал” жүжигчилсэн тоглолтоо сонирхуулснаас гадна сагсан бөмбөг, холын зайн гүйлт, зураг эвлүүлэх зэрэг тэмцээн уралдаан зохион байгуулж, шалгарагсдад шагнал гардуулжээ. Цогтцэций сумын ерөнхий боловсролын сургуулиудын тэргүүний сурагчид болон эмзэг бүлгийн хүүхдүүдэд гарын бэлэг гардуулж, “Хас” кинотеатртай хамтран 110 хүүхдэд үнэ төлбөргүй кино үзүүлсэн байна.



Интермед эмнэлэг тэргэнцэртэй 60 гаруй хүүхдүүдийг эрүүл мэндийн үзлэгт үнэ төлбөргүй хамруулан, эцэг эхчүүдэд нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хоол, сэтгэл зүйн болон хөдөлгөөн заслын зөвлөгөө өгч гарын бэлэг гардуулжээ.

Скай Резорт ХХК нь “Өнөр бүл” хүүхдийн төвийн 150 хүүхдийн 3 сая төгрөгийн зардлыг дааж цана, чарга, лифтээр үйлчилсэн ба нийгмийн эмзэг бүлгийн 1000 хүүхдийн “Цасны баяр”-ыг ээлжит удаагаа үнэ төлбөргүй зохион байгуулжээ.

Анунгоо ХХК нь Хүүхдийн төв сувилалд хэвтэн эмчлүүлдэг хөгжлийн бэрхшээлтэй бага насны хүүхдүүдийн хэрэгцээнд зориулан 2 сая төгрөгийн живх бэлэглэснээс гадна хэвтэн эмчлүүлж байсан бүх хүүхдүүдэд “Kinder” брэндийн гарын бэлэг өгчээ. Түүнчлэн 2017 оны 1-9 дүгээр сарын хугацаанд Улаанбаатар, Дархан, Эрдэнэт хотын төрөх эмнэлгүүдэд амаржсан эхчүүдэд бүтээгдэхүүнийхээ дээж болон хүүхэд асрах зөвлөмж бүхий ном бэлэглэжээ. Мөн Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв, “Нийслэл өргөө”, “Амгалан” амаржих газруудын зарим тасгуудыг тохижуулж өгчээ.



Энержи Ресурс ХХК нь 2013 онд Өмнөговь аймгийн ЗДТГ-тай хамтран Цогтцэций суманд “Мөрөөдөл” сургууль, цэцэрлэгийн цогцолбор байгуулаад зогсохгүй Улаанбаатар хотоос мэдлэг, туршлагатай багш, удирдлагыг урьж ажиллуулах, англи хэл, математикийн гүнзгийрүүлсэн 2017 онд компанийн санаачилгаар Цогтцэций сумын ЗДТГ болон “Мөрөөдөл” цогцолбор

сургалт нэвтрүүлэх зэргээр боловсролын менежментийн цогц хөтөлбөр хэрэгжүүлж ирлээ. сургуультай гурван талт санамж бичиг байгуулж түүний хүрээнд шилжин ирсэн чадварлаг багш, ажиллагсдыг орон нутагт тогтвор суурьшилтай ажиллуулахад нь дэмжлэг үзүүлэх үүднээс “Цэций” хорооллын 483 сая төгрөгийн үнэ бүхий 6 орон сууцыг тус сургуульд үнэ төлбөргүй олгосон байна.



Орчлон сургууль цэцэрлэгийн цогцолбор боловсрол сургалтын байгууллага /БСБ/ нь алслагдсан зарим сумдын сургуулиудын номын санг шинэ номоор баяжуулах зорилгоор “Номын хандивын аян”-г сурагчдынхаа дунд зохион байгуулсан бөгөөд нийт 352 ном цугларсныг гардуулж өгчээ. Мөн тус сургуулийн 6с ангийн сурагчид Ховд аймгийн Дарви сумын дунд сургуульд 132 ном, дасгалын ажлын 50 дэвтэр хандивласан байна. Мөн Төв аймгийн Эрдэнэ сумын “Номин” цэцэрлэгийн хамт олны хүсэлтээр сургалтын орчинг нь сайжруулахад туслах хандивыг зохион байгуулжээ.

ЭРҮҮЛ МЭНДИЙГ ДЭМЖСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА



Интермед эмнэлэг нь 2017 онд нийгмийн хариуцлагынхаа хүрээнд нийт 58,6 сая төгрөгтэй тэнцэх эрүүл мэндийн эмчилгээ, үйлчилгээг үнэ төлбөргүй хийсэн байна. Тухайлбал, ходоодны хорт хавдар болон улаан хоолойн гэмтэлтэй өвчтөнд эхний шатны мэс заслыг үнэ төлбөргүй хийж, Улаанбаатар хотод зохион байгуулагдсан Ази Номхон далайн орнуудын чуулга уулзалтын үеэр эмнэлгийн яаралтай тусламжийн үйлчилгээг хариуцан оролцжээ. Түүнчлэн ЭМЯ, Хавдар судлалын үндэсний төв, Монголын яаралтай тусламжийн нийгэмлэг, Тайвань улсын яаралтай тусламжийн нийгэмлэг, Монгол-Японы эх баригч эмч нарын нийгэмлэгүүдээс зохион байгуулсан семинар, сургалтад илтгэгч болон ивээн тэтгэгчээр оролцсоноос гадна нийслэлийн “Амгалан” амаржих газарт хандив өгсөн юм.

Олон нийтэд хандсан 12 удаагийн семинар, мэргэжилтнүүдэд чиглэсэн 10 удаагийн семинар, “Олон улсын



“JCI магадлан итгэмжлэлийн стандартууд” цуврал семинар, “Дэлхийн үжлийн эсрэг өдөр” нийслэлийн болон хөдөө, орон нутгийн эмч нарт видео хурал зохион байгуулсан байна. Юнител группийн хамт олон “Цус хандивлах аян”-д нэгдсэнээр 249 хүний амь насыг аврах боломжийг бүрдүүлсэн байна.



Сагсан бөмбөгийн спортыг дэмжигч Спрайт брэндээс жил бүр “Спрайт бүх оддын тоглолт”-ыг зохион байгуулдаг бөгөөд тэмцээний аварга баг шагналын сангаасаа сайн үйлсийн аянд хандивладаг уламжлалтай. 2017 оны аврагууд маань Архангай, Булган, Баянхонгор, Дундговь зэрэг аймгийн эрүүл мэндийн нэгдсэн төвүүдэд нярайн шарлалт хэмжигч хандивласан байна.

СОЁЛ, УРЛАГ, СПОРТЫГ ДЭМЖСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА



М-Си-Эс Кока-Кола ХХК нь FIBA сагсан бөмбөгийн 3x3 төрлийн Азийн аварга шалгаруулах тэмцээнийг ивээн тэтгэж Монгол Улсад анх удаа амжилттай зохион байгууллаа. Тус тэмцээн нь сагсан бөмбөг сонирхогч залуусыг идэвхжүүлэх, эрүүл идэвхтэй амьдралын хэв маягийг олон нийтэд сурталчлах, цаашлаад Монголын баг тамирчдаа тив, дэлхийд таниулах өргөн боломж байв. Тэмцээнд Монгол Улсын баг тамирчид амжилттай оролцож Азийн аваргаар шалгарч, Токио 2020 олимпод оролцох эрхийн төлөөх тэмцээнд хүч үзэх боломж нээгдсэн юм. Монгол Улсын 3x3 сагсан бөмбөгийн баг тамирчид олон улсын хэмжээнд өмнө нь 183-р байрт эрэмблэгддэг байсан бол Азийн аваргын цом гардсанаар 28-р байр руу дэвшсэн билээ.

М-Си-Эс групп нь сагсан бөмбөгийн спортыг эх орондоо хөгжүүлэхийн төлөө олон жил зүтгэж ирсэнээ үргэлжлүүлж 3x3 төрлийн Азийн аваргаар шалгарсан Монгол Улсын шигшээ багийг илүү



өндөр амжилтад хүргэхээр дэмжин ажиллаж байна. Тодруулбал, Токиогийн олимп хүртэл буюу 2018-2020 оны хооронд гурван жилийн хугацаанд шигшээ багийн дасгалжуулагч болон тамирчдад сар болгон хүн тус бүрт нэг сая төгрөгийн мөнгөн шагнал тогтмол олгохоор шийдвэрлэж, мөн Будда Виста Клубын гишүүнчлэлийн эрхээр урамшуулсан юм.



М-Си-Эс Кока-Кола ХХК нь 2015 оноос Тусгай олимпод оролцох баг тамирчдад дэмжлэг үзүүлж ирлээ. Өнгөрсөн онд тус компани оюуны бэрхшээлтэй хүмүүст спортын уралдаан, тэмцээнээр дамжуулан урам өгөх, бие бялдрыг нь хөгжүүлэх, тэднийг эрүүл хүмүүстэй адил тэгш эрхтэй иргэн гэдгийг нь олон нийт, нийгэмд таниулах зорилгоор зохион байгуулагддаг Тусгай олимпийн өвлийн наадамд оролцох баг тамирчдын хувцас хэрэглэлийн зардлыг бүрэн хариуцлаа.



Скай Резорт ХХК нь Монголын мэргэжлийн снөүбоардын холбооны 4 тамирчинд улирлын турш бэлтгэл сургуулилт хийх 2 сая төгрөгийн үнэ бүхий эрх олгосноос гадна снөүбоардын тэмцээн зохион байгуулахад дэмжлэг үзүүлж хамтран ажиллалаа. Өвлийн олимпод Монгол Улсаа төлөөлөн оролцдог гүйлтийн цанын тамирчдын бэлтгэлийг хангуулах, дараагийн үеийг бэлтгэх, хүүхэд залуучуудын дунд энэ төрлийн спортыг хөгжүүлэхэд зориулан 1,5 км гүйлтийн цанын стандарт замыг жил бүр 23,6 сая төгрөгийн өртөгтэй байгуулж байна. Мөн олон улсын тэмцээнд оролцох эрх авсан Монголын гольфын холбооны тамирчинд 40 удаа гольф тоглох 5,6 сая төгрөгийн эрх олгож бэлтгэл хангах, ур чадвараа сайжруулахад хувь нэмрээ оруулжээ.

Энержи Ресурс ХХК нь соёлын биет болон биет бус өвийг хамгаалах, хадгалах хүрээнд “Цогт цагийн хүрдэн” соёлын төвийн хүсэлтийг хүлээн авч, 2013 оноос “Ганжуур”, “Данжуур” их хөлгөн судрыг кирилл бичигт хөрвүүлэн нийтийн хүртээл болгох үйлсийг дэмжин “Санхүүгийндэмжлэг үзүүлэх гэрээ” байгуулан ажиллаж байна.

Уг төсөл нь уламжлалт өв соёлоо сэргээх, түгээн дэлгэрүүлэх, орчин цагийн монгол хэлний үгсийн санг баяжуулах, үндэсний бахархлыг бий болгох өндөр ач холбогдолтой юм.



Одоогоор их хөлгөн судрын эхний 120 гаруй ботийг хөрвүүлэн хэвлүүлж, Улаанбаатар хот дахь компанийн төв оффис, Цогтцэций сумын соёлын төвийн номын сан, Ухаа Худаг дахь салбарт тус тус хүндэтгэн залжээ.



Өмнөговь аймгийн Цогтцэций суманд тав дахь жилдээ зохион байгуулсан “Ухаа худагийн наадам” нь бүтээн байгуулалт, түүнийг дагасан их ажил үйлсийн баяр болоод зогсохгүй нутгийн олон түмний хамтаар уул ус, газар орондоо мялаалга өргөж, төрт ёсны уламжлалаа сэргээх боломж олгодог уламжлалт ёслол болжээ.

2017 оны 8 дугаар сарын 4-5-ны өдрүүдэд зохион байгуулагдсан “Ухаа Худаг 2017” наадамд нутаг нутгийн хүчит бөхчүүд, алдарт уяачид, эрхий мэргэн харваачид өргөнөөр ирж өрсөлдсөн юм. “Цэций жонон” морин хуурын хамтлаг, Ханхонгор сумын урлагийн баг, аймгийн Хөгжимт жүжгийн театрын уран бүтээлчид говь нутгийнхаа өв соёлыг сурталчлан таниуллаа. Наадамчин олны дундаас үндэсний дээл хувцсаараа иж бүрэн гоёсон сайхан хос шалгаруулж, шагнан урамшуулсаар ирсэн нь монгол түмний эртний сайхан уламжлалыг сэргээх зорилготой бөгөөд өдгөө Ухаа Худаг наадмын сонирхолтой нэгэн чимэг болж чаджээ.



“Бидний цөөхөн Монголчууд”

төслийг ивээн тэтгэж байна
Монгол орны онгон дагшин байгаль, баялаг түүх, соёлыг ирээдүй хойч үед таниулах, мөнхлөн үлдээх зорилготой “Бидний цөөхөн Монголчууд” төслийн ерөнхий ивээн тэтгэгчээр Энержи Ресурс ХХК, хамтран хэрэгжүүлэгчээр Юнител ХХК ажиллаж байна.

М-Си-Эс групп нь хамтрагч, хэрэглэгч, түншүүдийнхээ эрх ашгийг ямагт хүндэтгэн үзэж хамтран ажиллах, найдвартай, шуурхай ажил үйлчилгээ үзүүлэх, чанартай бүтээгдэхүүнээр хангах чиглэлээр дараах ажлыг хийж хэрэгжүүлжээ.

Юнител групп нь 2017 онд Монгол Улсын өрхийн интернэтийн хөгжлийг шинэ шатанд авчирсан бүтээгдэхүүнийн зах зээлд нэвтрүүлсэн нь “Гэр интернэт” байв. Уг үйлчилгээг нэвтрүүлснээр Улаанбаатар хотын гэр хороолол болон орон нутгийн 600,000 айл өрх интернэтэд холбогдох боломж нээгдсэн юм. Ингэснээр хөдөө орон нутаг, алслагдсан газарт амьдардаг хүмүүс ч гэрээсээ суурин утсаар ярьж, өндөр хурдны интернэт ашиглах боломжтой болсон билээ. Энэхүү бүтээгдэхүүн үйлчилгээг зах зээлд нэвтрүүлэхэд 9,1 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийжээ.



Мөн IPTV, интернэт, суурин утасны гурвалсан үйлчилгээг орон нутагт нэвтрүүлж байгаа нь технологийн хөгжлөөр дамжуулан дэлхийн

хөгжилтэй хөл нийлүүлэх том алхам болж байна. Одоогийн байдлаар Улаанбаатар, Дархан, Эрдэнэт хотууд болон 18 аймагт Юнивишнийн гурвалсан үйлчилгээг нэвтрүүлээд байна.



М-Си-Эс Кока-Кола ХХК нь жил бүр хэрэглэгчийн таашаалд нийцэх амтыг эрэлхийлж, шинэ бүтээгдэхүүнийг хэрэглэгчдэдээ санал болгодог. 2017 онд Кока-Кола ундааг 300 мл, Schweppes +C, Kiwi бүтээгдэхүүнийг 500 мл савлагаатайгаар үйлдвэрлэж эхэлснээс гадна илчлэггүй, сахаргүй Sprite Zero шинэ бүтээгдэхүүнийг 500 мл савлагаатайгаар зах зээлд амжилттай танилцуулжээ.



Тус хамт олон нь хэрэглэгчдэдээ бүтээгдэхүүнийг хэрхэн үйлдвэрлэдэг шат дамжлагын талаар мэдээлэл өгөх зорилготой “Үйлдвэртэй танилцах хөтөлбөр”-ийг

2008 оноос эхлүүлсэн бөгөөд 2017 онд 103 удаагийн аялалаар 4526 зочин үйлдвэртэй танилцсан байна. Хөтөлбөр хэрэгжиж эхэлснээс хойшхи есөн жилийн хугацаанд нийт 1903 удаагийн аялалаар 50 мянга гаруй зочид уг хөтөлбөрт хамрагдан үйлдвэртэй танилцжээ.



М-Си-Эс Кока-Кола ХХК нь хүүхэд залуусын чөлөөт цагаа зөв боловсон өнгөрөөх, хувь хүний хөгжилд чиглэсэн сайн дурын үйл ажиллагааг зохион байгуулахад чиглэсэн “Happiness center” төвийг 2012 оноос хойш ажиллуулж байна. Тус төвд лекц семинар зохион байгуулах танхим, сонирхсон номоо унших номын булан, авьяас чадвараа хөгжүүлж бэлтгэл сургуулилт, тоглолт хийх тайз, тоног төхөөрөмжөөс гадна үнэ төлбөргүй Wi-Fi орчин, X-BOX тоглоомууд бий. 2017 онд “Happiness center”-ээр үйлчлүүлэгчдийн тоо хоногт 250-300 болсон нь өнгөрсөн жилтэй харьцуулахад 3 дахин өссөн үзүүлэлт юм. Тайлант онд тус төв нь 45 байгууллагатай хамтран 145 удаагийн үйл ажиллагаа зохион байгуулж, нийт 17 мянга орчим хүнд хүрч үйлчилсэн байна. 2012 оноос хойш тус төвөөр нийтдээ 227 мянга гаруй хүүхэд залуус үйлчлүүлжээ.



Энержи Ресурс ХХК нь 2009 оноос өмнө найдвартай цахилгааны эх үүсвэргүй байсан Цогтцэций сумын төвийг 24 цагийн эрчим хүч, ундны цэвэршүүлсэн усаар байнга хангаж байна. Тайлант 2017 онд 38 мянган м³ цэвэршүүлсэн ус, 8,8 сая кв/цаг эрчим хүчийг орон нутагт улсын суурь үнээр нийлүүлж, нийт 1,3 тэрбум төгрөгийн зардал гаргажээ. Түүнчлэн аймаг, сумдын зайлшгүй хэрэгцээнд зориулж эрчим хүчний нүүрсийг жил бүр үнэ төлбөргүй нийлүүлж ирлээ. 2017 онд Даланзадгадын дулааны цахилгаан станц болон Өмнөговийн сумдын өвөлжилтийн хэрэгцээнд нийт 470 орчим сая төгрөгийн өртөг бүхий 32 мянган тонн эрчим хүчний нүүрс нийлүүллээ.





Интермед эмнэлэг 2017 онд үе мөч, уламжлалт анагаахын эмчилгээ, бөөр шээсний замын мэс заслын тусламж үйлчилгээг шинээр нэвтрүүллээ. Иргэд, хэрэглэгчдийн эрүүл мэндийн боловсролыг дэмжих зорилгоор “Гарын эрүүл ахуйн өдөрлөг”, “Эрүүлхооллолтын өдөрлөг” болон Дэлхийн эрүүл мэндийн өдрөөр үйл ажиллагаа зохион байгуулж, Фортис, Анам, Раффлес эмнэлгүүдтэй хамтран 3,5 сая төгрөгийн үзлэг, лекцийг үнэ төлбөргүй хийжээ. Мөн хэрэглэгчдийн сэтгэл ханамжийг дэмжих хүрээнд Олон улсын Хүүхдийн эрхийг хамгаалах өдөр, Шинэ жилийн баярын өдрөөр үйлчлүүлэгч нартаа гарын бэлэг өгчээ.

“Монгол эрүүл хүн” зорилтын хүрээнд Куба улсаас 3 эмчийг урилгаар авчран хагас жилийн хугацаанд хөнгөлөлттэй үнээр үзлэг оношилгоо, мэс засал хийлгэж байна.

Скай Резорт ХХК нь цанын улирлын турш хүүхэд, залууст чөлөөт цагаа зөв боловсон,

эрүүл агаарт идэвхтэй өнгөрөөхөд дэмжлэг үзүүлэн Лхагва, Пүрэв гарагт 50 хувийн хөнгөлөлттэй үнээр үйлчилгээ үзүүллээ. Түүнчлэн нийслэлийн төв хэсэг болон цанын баазын хооронд хоёр чиглэлд нийтийн тээврийн үйлчилгээг үнэ төлбөргүй явуулжээ.

Скай Резорт Автобусны цагийн хуваарь

Шангри-Ла Молл-ийн зүүн талын авто зогсоол

УБ-иас хөдлөх	Цанын баазыг	УБ-иас хөдлөх	Цанын баазыг	УБ-иас хөдлөх	Цанын баазыг	УБ-иас хөдлөх	Цанын баазыг
10:30	12:00	10:30	12:00	09:30	10:00	09:30	10:00
13:00	14:00	13:00	14:00	11:00	12:00	11:00	12:00
15:00	17:30	15:00	17:30	13:00	14:00	13:00	14:00
18:30	21:30	18:30	22:30	15:00	18:00	15:00	18:30
				19:00	22:30	19:00	20:30

Лхагва/Пүрэв 11:00-21:00 | Бөхдөр 11:00-22:00 | Бямба 10:00-22:00 | Ням 10:00-20:00

Shangri-La Mall | Sky Resort

www.skyresort.mn
facebook/skyresort.llc

БАЙГАЛЬ ОРЧИН

Бидний эрхэлж байгаа бизнесийн бүхий л үйл ажиллагаа нийгэмд үр өгөөжтэй, байгаль орчинд сөрөг нөлөөгүй байх зарчмыг дээдэлж, холбогдох хууль тогтоомжуудыг сахин биелүүлж ирлээ. Ингэхдээ юуны өмнө нийгэм, байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн үнэлгээг хийлгэн олон улсын сүүлийн үеийн стандартад нийцсэн техник, технологийг оруулж ирж, чанартай бараа бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж байна. Өнгөрөгч 2017 онд байгаль орчноо хайрлан хамгаалах чиглэлээр Юнител ХХК нь ой хээрийн түймрийн голомтод ажиллаж буй албан хаагчдад IRIDIUM үйлчилгээ, үүрэн холбооны сүлжээний явуулын станц илгээж, 25 сая төгрөг хандивлах, М-Си-Эс Кока-Кола ХХК байгальд хоргүй 20 мянган био уутыг тусгай хамгаалалттай газруудад хүлээлгэн өгөх, М-Си-Эс Проперти ХХК “Байгальд ээлтэй хамт олон” аян өрнүүлэх, Энержи Ресурс ХХК зэрлэг ан амьтдад уст цэг байгуулах зэрэг томоохон ажлуудыг хийжээ.



Энержи Ресурс ХХК нь Цэций хайрхан уулын аргаль, янгирт зориулан өвс, мөс, хужир тавьж өгөх ажлыг жил бүр зохион байгуулдаг бөгөөд 2017

онд сумын байгаль хамгаалагчидтай хамтран уг ажлыг зохион байгууллаа. Мөн Өмнөговь аймгийн Ханбогд суманд өвлийн улиралд зэрлэг ан амьтдыг өлдөж, харангадах аюулд өртөхөөс хамгаалж уст цэг байгууллаа. Тус сумын “Говийн бага дархан цаазат газар”-ын ажилтнууд болон байгаль орчны байцаагчтай хамтран Цагаан хадны ойролцоо, уулын энгэрт цөөрөм гаргаж усаар дүүргэсэн байна.




“Орчлон сургууль цэцэрлэгийн цогцолбор” боловсрол сургалтын байгууллага нь сурагчдаа байгаль орчиндоо ээлтэй, эрүүл, зөв амьдралын дадал хэвшилтэй болгох үүднээс жил бүрийн 4-р сард “Эко өдөр” ажиллагааг зохион байгуулж хэвшсэн. Хогны менежментийн аян зохиож, хогийг ангилан ялгадаг нь сурагчдад бага наснаас хогоо зөв ангилж хаях, хог хаягдлаа багасгах амьдралын зөв дадал хэвшлийг бий болгох ач холбогдолтой юм. Орчлон сургуулийн сурагчид, багш нар, эцэг эх хамтран Үндэсний цэцэрлэгт хүрээлэн дэх “Орчлон төгөл”-д жил бүр мод тарьдаг уламжлалтай бөгөөд одоо 250 гаруй мод тариад байна.

М-Си-Эс Кока-Кола ХХК нь Байгаль орчны удирдлагын ISO 14001:2004 тогтолцоог нэвтрүүлэн үйл ажиллагаагаа чанараар баталгаажуулсаар байна.

Байгаль орчиндоо ээлтэй байх, бүтээгдэхүүний өртөг бууруулах ажлын хүрээнд:

- Нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд нөлөөлөх ус, эрчим хүч, хог хаягдал, аюултай хог хаягдал зэрэг байгаль орчинд нөлөөлөх үзүүлэлтүүдийг жил бүр бууруулах зорилт тавин ажиллаж байна. Нэг литр бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд



зарцуулах усны хэмжээг 2005 оноос хойш 67 хувиар бууруулж, 2017 онд ус ашиглалт ус/л ундаа - 1.71 литр ус/л ундаа болж буурчээ.

Үйлдвэрлэлийн үйл ажиллагаанаас болж гардаг хог хаягдлыг ангилан ялгаж дахин боловсруулах үйлдвэрүүдэд өгч хоёрдогч түүхий эд, бараа бүтээгдэхүүн болгож байна. Хог хаягдлын 55 хувийг дахин ашиглах түүхий эд болгон тушаасан. Гялгар уут болон хуванцар савыг Сан-Оргиу ХХК-д өгч сандал, хашаа, хайс хийн үйлдвэрийн хэсэгт байршуулжээ.




М-Си-Эс Проперти ХХК нь 2018 онд “Байгаль орчны менежментийн тогтолцоо ISO14001:2015” стандартыг нэвтрүүлэх ажлын хүрээнд “Байгаль орчны менежмент” сургалтыг ажиллагсдынхаа дунд зохион байгууллаа. Ингэснээр оффисын хэмжээнд “Ногоон дүрэм” батлан хэрэгжүүлж, “Бид байгальд ээлтэй хамт олон” аян өрнүүлж байна. Байгууллагын үйл ажиллагаанаас



М-Си-Эс Проперти ХХК нь 2018 онд “Байгаль орчны менежментийн тогтолцоо ISO14001:2015” стандартыг нэвтрүүлэх ажлын хүрээнд “Байгаль орчны менежмент” сургалтыг ажиллагсдынхаа дунд зохион байгууллаа. Ингэснээр оффисын хэмжээнд “Ногоон дүрэм” батлан хэрэгжүүлж, “Бид байгальд ээлтэй хамт олон” аян өрнүүлж байна. Байгууллагын үйл ажиллагаанаас шалтгаалан байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах зорилгоор ажиллагсаддаа сургалтаар мэдлэг олгон, байгаль орчноо хайрлах зөв дадал эзэмшүүлэх дараах 3 хэмнэлтийг хэвшүүлж байна.

Үүнд:

1. Эрчим хүч хэмнэх
2. Цаасны хэрэглээг бууруулан хэмнэх
3. Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан хаях, дахин боловсруулах үйлдвэрт тушаах



Юнител ХХК нь 2017 онд манай улсын нутаг дэвсгэрийн багагүй хувийг хамарч гамшгийн хэмжээнд хүрсэн ой, хээрийн түймрийн голомтод ажилласан онцгой байдлын албан хаагчдад туслах зорилгоор сансрын холбооны IRIDIUM үйлчилгээ, үүрэн холбооны сүлжээ цацах явуулын станцаа илгээснээс гадна тэдэнд 4 тонн цэвэр ус хүргүүлж, Онцгой байдлын ерөнхий газарт 25 сая төгрөг хандивлав. Мөн ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх зөвлөмжийг үүрэн холбооны 1,2 сая хэрэглэгчдэд, сэрэмжлүүлэг мэдээг Юнивишн, ДДэшТВ-ийн мэдээллийн сувгаар 434 мянган өрхөд хүргэжээ. Олон нийтийн сүлжээгээр “Ногоон байгаасай” аян өрнүүлж, Юнител группийн ажилтнууд Туул голын эрэг орчмын хогийг цэвэрлэлээ.



ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГО

М-Си-Эс групп нь бизнесийн зургаан чиглэлд, 20 орчим компанийн 8000 гаруй ажиллагсадтайгаар үйл ажиллагаагаа явуулж, “Дэлхийн хөгжлийг Монголдоо цогцлоох” эрхэм зорилгын дор эх орныхоо хөгжил цэцэглэлт, бүтээн байгуулалтанд хувь нэмрээ оруулах нэгэн үзүүрт сэтгэлээр хичээл зүтгэл гарган ажиллаж ирлээ.



ЭРЭГТЭЙ
57,7%



ЭМЭГТЭЙ
42,5%

ХҮНИЙ ЭРХ

Тус групп нь Хүний эрхийг дээдлэн ажилладаг бөгөөд хүний нөөцийн бодлого, байгууллагын соёл, ёс зүйн дүрмийн хүрээнд хүнийг нас, хүйс, шашин, шүтлэг, боловсролын түвшингээр ялгаварлан гадуурхдаггүй.

М-Си-Эс группт ажиллагсдын насыг 20 хүртэлх, 20-50, 50-иас дээш гэж ангилж болох бөгөөд дундаж нас нь 34 юм.

Нийгмийн эмзэг бүлгүүдийг ялгаварлан гадуурхсан аливаа үйл ажиллагаа үл явуулах, бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэхгүй байх бодлогыг тууштай баримталж хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ажлын байраар хангахад анхаарч ирсэн. 2017 оны байдлаар М-Си-Эс группийн хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй 48 иргэн тогтвортой хөдөлмөр эрхэлж байна.

АЖИЛЛАГЧДЫН ДУНДАЖ НАС



34

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ



48

СУРГАЛТ

М-Си-Эс группийн Сургалт хөгжлийн алба нь 2005 оноос эхлэн дотоодын сургалтуудаа зохион байгуулж ирсэн бөгөөд 2008 оноос М-Си-Эс Академи нэрээр үйл ажиллагаагаа явуулж байна. Тус академи нь М-Си-Эс группийн үнэт зүйлсийг түгээн хөгжүүлж, дэлхийн жишигт хүрсэн байгууллагын чадавхийг бүрдүүлэх, компанийн эрхэм зорилгыг дэмжих 30 гаруй сургалтыг зохион байгуулдаг. 2017 онд гэхэд 149 удаагийн сургалтад 2306 ажилтан хамрагджээ. Сургалтад хамрагдсан ажилтнууд сургалтыг үнэлдэг бөгөөд 2017 онд дундаж оноо 4.67 байгаа нь өнгөрсөн жилээс ахисан үзүүлэлт юм.

Түүнчлэн компаниуд ажиллагсадаа мэргэшүүлэх чадавхжуулах болон ерөнхий мэдлэг олгох сургалтыг дотооддоо зохион байгуулдаг. Тухайлбал, Энержи Ресурс ХХК нь 2017 онд давхардсан тоогоор нийт 4,000 гаруй залуучуудыг мэргэжлийн болон дадлагажуулах сургалтад хамруулан бэлтгэсэн байна. М-Си-Эс Кока-Кола ХХК нь ажилтнуудын ажил, сургалт хөгжлийн төлөвлөгөөний дагуу 213 удаагийн сургалт зохион байгуулж, давхардсан тоогоор 2,127 ажилтнуудыг хамруулжээ. Үүний дотор, Соса-Кола компаниас маркетинг, борлуулалтын мэргэжлийн багш нарыг урьж ирүүлэн өөрийн төдийгүй

М-Си-Эс группийн бусад борлуулалтын компаниудын удирдах ажилтнуудыг гурван удаагийн сургалтад хамруулаа. Интермед эмнэлэг нь ажилтнуудаа тасралтгүй боловсрол олгох ажлын хүрээнд олон улсын туршлага судлах сургалтад тогтмол хамрагдаж хэвшжээ.

НИЙГМИЙН ХАЛАМЖ

М-Си-Эс группийн хэмжээнд “Хөдөлмөрийн тухай хууль”, “Нийгмийн даатгалын тухай хууль”-ийн дагуу дотоод журмуудаа боловсруулан мөрдөж ажилладаг ба ажиллагсдын нийгмийн хамгааллын талаар “Хөнгөлөлт хангамжийн тухай” журмыг баримталж байна. Нийт ажиллагсдаа 2-3 жилд нэг удаа эмнэлгийн бүрэн үзлэг шинжилгээнд үнэ төлбөрийг компаниас даан хамруулж хэвшсэн. Ажлын байрны онцлог, нөхцөлөөс хамаарч заавал хийгдэх шаардлагатай үзлэг, оношилгоонд хуулийн заасан хугацаанд хамруулж ирлээ.

М-Си-Эс Кока-Кола ХХК нь нэг удаагийн буцалтгүй тусламжийг 24 хүнд, хоолны хөнгөлөлтийг 540 хүнд, үүрэн утасны хөнгөлөлтийг 338 хүнд тус тус үзүүлжээ. Мөн хүүхэдтэй болсон 80 хүнд эрхийн бичиг гардуулсан байна.

Скай Резорт ХХК нь ажилтнуудынхаа хоол, ажлын хувцас, унаа, даатгал, эрүүл мэндийн үзлэг болон хуулийн дагуу журамд заагдсан хөнгөлөлт хангамжуудыг хэрэгжүүлэн ажилладаг. 2017 онд гал түймрийн аюулын улмаас орон гэргүй болсон нэг ажилтанд компаниас шинэ гэр олгож, ажиллагсад хандив цуглуулан өгсөн байна.

Интермед ХХК нь ажиллагсад болон тэдний гэр бүлийн гишүүдэд эмнэлгийн тусламж үйлчилгээг хөнгөлөлттэй үзүүлдэг. Нийт ажиллагсадаа эрүүл мэндийн үзлэг, урьдчилан сэргийлэх вакцинд хамруулдаг ба хоолны хөнгөлөлт үзүүлж, чөлөөт цагаараа биеийн тамираар хичээллэх боломжийг бүрдүүлсэн спорт заалтай болжээ.

Юнисервис Солюшн ХХК нь хамт олныхоо дунд “Сайн үйлсийн аян” зохион байгуулахын зэрэгцээ үйлчилгээний нэмэлт ажлуудын орлогоороо 1 ажилчиндаа дэмжлэг үзүүлэн буцалтгүй тусламж олгожээ.



“Бид нэг гэр бүл” өдөрлөгийн хүрээнд хөдөлмөр хамгаалал, аюулгүй байдлын сургалт сурталчилгаа, дархлаажуулалтын аян, эрүүл мэндийн зөвлөмж, үзлэг зэрэг олон талт арга хэмжээ зохион байгууллаа.



Юнител групп нь ажилтнуудынхаа эрүүл мэндийг хамгаалах, өвчлөлийг эрт илрүүлэх, дэмжих зорилгоор Интермед эмнэлэгт урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулснаас гадна эрүүл мэндийн өдөрлөг, вакцинжуулалт, витаминжуулалт, ариутгал халдваргүйжүүлэлтийг тогтмол зохион байгуулдаг. “Эрдэст ус-эрүүл мэнд” өдөрлөг зохион байгуулж, ус эрдэсжүүлэгч аппаратыг 150 ажилтан өдөр тутам ашигладаг. Компаниас нэгдсэн байдлаар зохион байгуулснаар 200 гаруй ажилтан хөнгөлөлттэй нөхцөлөөр Голден Жим фитнес клубт хичээллэж байна.

Орчлон сургууль цэцэрлэгийн цогцолбор БСБ нь багш, ажилтнуудынхаа нийгмийн асуудлыг шийдвэрлэх хүрээнд нийт 54 багш, удирдлагын хүүхдүүдийг сургалтын төлбөрөөс чөлөөлдөг. “Экспресс” лабораторитай хамтран ажилтнуудыг эрүүл мэндийн шинжилгээнд 20 хувийн хөнгөлөлттэй хамруулан эмчийн зөвлөгөөг үнэ төлбөргүй өгүүлсэн. Өвлийн утаатай улирлаар 2 үйлчлэгчид цахилгаан халаагуур бэлэглэн нүүрс хэмнэхэд нь туслалцаа үзүүлжээ.

Анунгоо ХХК нь хөнгөлөлт, хангамжийн журам, бодлогын дагуу ажилтнуудад чиглэсэн хөнгөлөлт, хангамжийг олгож байна.

Тухайлбал

- Анунгоо ХХК төдийгүй М-Си-Эс группийн үндсэн ажилтан анх удаа хүүхэдтэй болоход бүтээгдэхүүн авах эрхийн бичиг
- Цагаан сарын баярыг тохиолдуулан 55 ба түүнээс дээш настай ажиллаж буй болон тэтгэвэрт гарсан ажилтнуудад бэлэг зэрэг.

М-Си-Эс Проперти ХХК нь 2018 онд Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын менежментийн тогтолцоо OHSAS 18001:2007 стандартыг нэвтрүүлэх зорилтын хүрээнд “Эрүүл-аюулгүй ажлын байрыг эрхэмлэгч байгууллага” болох хөтөлбөр гаргаж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Мэргэжлээс шалтгаалах өвчлөлөөс сэргийлэх, эрүүл аюулгүй ажиллах дадал соёл төлөвшүүлэх ажлуудыг зохион байгуулж байна. Компанид үр бүтээлтэй ажиллаж байгаа боловч өрхийн орлого багатай ажилтнууддаа 2013 оноос эхлэн Вива Сити хотхонд хоёр байрыг хөнгөлөлттэй үнээр түрээслүүлж ирлээ.

М-Си-Эс групп нь “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай” хуулийн хүрээнд боловсруулсан “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт зохион байгуулах, ур чадварын үнэлгээ хийх журам”, “Ажилтнуудыг эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд хамруулах ажлыг зохион байгуулах тухай журам”, “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ослыг бүртгэх, судлан тогтоох журам”-уудыг тус тус мөрдөн ажиллаж байна. ХАБЭА-н бодлогодоо нийгэм, хүний аюулгүй байдал, эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд сөрөг нөлөөгүй үйл ажиллагаа явуулах зарчмыг тууштай баримталж ирсэн. Уг бодлогыг хэрэгжүүлэхийн тулд ХАБЭА-н удирдлагын тогтолцоог өндөр түвшинд хөгжүүлэх, ялангуяа сургалт, хяналт, үнэлгээг улам сайжруулах улмаар осол, гэмтлийн тохиолдлыг бууруулах чиглэлээр ажиллаж байна.

ХАБЭА-н удирдлагын тогтолцооны

аудит, үнэлгээ, зөвлөгөө

М-Си-Эс Холдинг компанийн зүгээс хагас жил тутам харьяа бүх компанийн ХАБЭА-н тогтолцоо, үйл ажиллагаанд үнэлгээ өгөх аудит хийдэг бөгөөд дүгнэлтэнд үндэслэн цаашид сайжруулах ажлын заавар, зөвлөмжийг цаг тухайд нь өгч хэрэгжилтэд хяналт тавьж ажилладаг.

ХАБЭА-н дотоод хяналт

М-Си-Эс группийн хэмжээнд ХАБЭА-н асуудал

хариуцсан 40 гаруй менежер, инженер, ажилтан ажилладаг. Эдгээр ажилтнууд нь хариуцсан компанидаа ХАБЭА-н өдөр тутмын үйл ажиллагааг зохицуулж, хяналт тавьж байна.

ХАБЭА-н сургалт

Группийн хэмжээнд нийт ажилтнууддаа эрүүл, аюулгүй ажиллах соёл, эерэг хандлага, зөв зан үйлийг төлөвшүүлэх зорилгоор ажлын байрны ХАБЭА-н сургалтуудыг тогтмол зохион байгуулж хэвшсэн. Шинээр ажилд орж байгаа болон өдөр тутам ажлаа гүйцэтгэж буй ажилтнуудад сургалт, зааварчилга өгөхөөс гадна удирдах ажилтнуудад ХАБЭА-н ойлголт, хууль эрх зүйн мэдлэг олгох сургалт, лекцийг дотооддоо зохион байгуулж байна.

Энержи Ресурс ХХК нь ХАБЭА-н сургалт, хяналтыг чанартай хийж хэвшснээр нийт ажиллагсад, гэрээт гүйцэтгэгч болон тэдгээрийн туслан гүйцэтгэгчид 6,623,801 хүн/цаг аваар осолгүй ажиллалаа. Хөдөлмөрийн чадвар түр алдалтын давтамжийн үзүүлэлт (ХЧТАД) 0.45 байгаа нь гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт болох 0.5-аас 10%-иар бага үзүүлэлт юм. МХЕГ, Өмнөговь аймгийн МХГ-ын хамтарсан хяналт шалгалтын хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын хуудсаар “бага эрсдэлтэй” буюу 83.5 үнэлгээтэй шалгагдсан юм.

М-Си-Эс Кока-Кола ХХК нь 2017 онд ХАБЭА-н үйл ажиллагаанд 145,4 сая төгрөг зарцуулсан бөгөөд ажиллагсдаа эрүүл мэндийн үзлэгт хамруулж, халдварт, эмэгтэйчүүд, элэгний В, С вирус болон тусгай нөхцөлд ажиллагсдыг хараа, сонсгол, цацрагийн шинжилгээнд оруулжээ.

Юнисервис Солюшн ХХК нь 2017 онд ХАБЭА-н үйл ажиллагаанд 35,3 сая төгрөг зарцуулж, 1,336,000 хүн/цаг аваар осолгүй ажиллалаа. ХАБЭА-н хүрээнд дараах ажлуудыг хийж хэвшүүлсэн. Үүнд:

- Ажилтан бүр өдөр тутмын зааварчилгааг тогтмол авч хэвшсэн
- Шинэ ажилтан, гэрээт болон дадлагын ажилтан бүрт ХАБЭА-н сургалт зааварчилгаа тогтмол өгч хэвшсэн
- ХАБЭА-н ажлын хувцас, хамгаалах хэрэгслээр ажилчдыг тогтмол хангаж, хяналт тавьж хэвшсэн
- Улирал бүр хуваарийн дагуу ХАБЭА-н сэдэвчилсэн сургалт явуулдаг.
- ХАБЭА-н стандартын сургалт, анхны тусламжийн сургалт, гал, гамшгийн сургалт зэрэг.
- ХАБЭА-н үйл ажиллагаатай холбоотой шаардлагатай хөрөнгө, төсвийг тооцож хэвшсэн,

- Шинэ ажлын байр болон эрсдэлтэй ажлын байр бүрт эрсдэлийн үнэлгээг тогтмол хийж, түүнийг арилгах арга хэмжээ авч хэвшсэн,
- Өөрсдийн хариуцсан ажлын байр бүрт тогтмол хуваарийн дагуу үзлэг шалгалт хийж хэвшсэн,
- Олон улсын аюулгүйн стандартын шаардлагад нийцсэн Petzl / ASAP/ VERTEX BEST/ PROTEC/ FOOTAPE зэрэг брэндийн хамгаалах хэрэгслүүдийг ашигладаг.

Анунгоо ХХК-ийн ХАБЭА хариуцсан ажилтан,

- Олон улсын болон Монгол Улсын ХАБЭА-н хууль, дүрэм, журам, зааврыг хэрэгжүүлэх
- ХАБЭА-н зөвлөлийг зохион байгуулж ажиллах
- Ажлын байрны эрсдлийн үнэлгээ хийж, аюул эрсдлийг бууруулах төлөвлөгөө боловсруулах
- Төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус ХАБЭА-н үзлэг, шалгалт хийх
- ХАБЭА-н анхан шатны болон давтан зааварчилгаа, мэдээлэл өгөх
- Гал, гамшгийн үед хэрхэн ажиллах зааварчилгаа, зөвлөмж өгөх
- Ажлын хувцас, хамгаалах хэрэгсэл, хор саармагжуулах бүтээгдэхүүнийг шаардлагатай ажлын байрны ажилтнуудад өгөх ажлыг хийж гүйцэтгэдэг юм.



Ж.ОДЖАРГАЛ ШИЛЖИЛТИЙН 25 ЖИЛИЙН ТОП БИЗНЕСМЭНЭЭР ШАЛГАРАВ

М-Си-Эс Группийн Захирлуудын зөвлөлийн дарга Ж.Оджаргал Монголын Залуучуудын Холбоо, “Залуу удирдагч” сан хамтран зохион байгуулдаг “Next stop” ёслол хүндэтгэлийн наадмын “Шилжилтийн 25 жилийн эдийн засаг, бизнесийн топ залуу”, “Алтан гэрэгэ” шагналын эзнээр шалгарлаа.

ТОП-100 ШАЛГАРУУЛАЛТАД М-СИ-ЭС ГРУППИЙН 11 КОМПАНИ ШАЛГАРЧ, ХУВИЙН ХЭВШЛЭЭ ТЭРГҮҮЛЛЭЭ

100 шалгаруулалтад М-Си-Эс группийн нийт 11 компани шалгарч, группийн амжилтаараа Эрдэнэт үйлдвэр ХХК-ийндараа буюу Монгол Улсын хэмжээнд хоёрдугаарт эрэмбэлэгдлээ. Тодруулбал, М-Си-Эс Холдинг ХХК, М-Си-Эс Интернэйшнл ХХК,



Юнител ХХК, М-Си-Эс Кока-Кола ХХК, М-Си-Эс Проперти ХХК, М-Си-Эс Азия Пасифик Брюэри ХХК, Спирт бал бурам ХХК, СББ Трейд ХХК, Шангри-Ла Улаанбаатар ХХК, Юнивишн ХХК, Анунгоо ХХК-иуд шалгарчээ.



АЖИЛТНУУДЫНХАА ЭРҮҮЛ МЭНД, НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАСАН ШИЛДЭГ 150 БАЙГУУЛЛАГЫН ТООНД ГРУППИЙН 8 КОМПАНИ ШАЛГАРЛАА

Нийгмийн даатгалын үндэсний Зөвлөлөөс ажилтнуудынхаа эрүүл мэнд, нийгмийн баталгааг сүүлийн 3-5 жилийн турш хангасан шилдэг 150 ажил олгогч, аж ахуй нэгжүүдийг шалгаруулан талархал гардууллаа. Уг шалгаруулалтыг Мобиком, АПУ, Саусгоби сэндс компаниуд тэргүүлсэн бөгөөд групп

компаниудаас М-Си-Эс группийн М-Си-Эс Холдинг, Гоёо, М-Си-Эс Проперти, Юнивишн, Шангри-Ла Улаанбаатар, СББ Трейд, Шангри-Ла Улаанбаатар Хотел, М-Армор гэсэн 8 компани орсон байна.



СҮҮЛИЙН ГУРВАН ЖИЛД 240 ОРЧИМ

НИЙГМИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ХЭРЭГЖҮҮЛЖЭЭ

“М-Си-Эс” групп нь 2015-2017 онд улсын төсөвт нийт 675.5 тэрбум төгрөгийн татвар, шимтгэл төлж улсын төсвийн орлогыг бүрдүүлэхэд хувь нэмрээ оруулжээ. Мөн, нийгмийн хариуцлагыг хэрэгжүүлэх чиглэлээр үндэсний өв, соёлоо өвлөн хөгжүүлэх, хүүхэд, залуучуудын боловсрол, хөгжилд дэмжлэг үзүүлэх, байгаль орчноо хайрлан

хамгаалах, эрүүл, идэвхтэй зөв амьдралын хэв маягийг бий болгох зорилготой 240 орчим үйл ажиллагааг хэрэгжүүлж, дэмжин ажилласан байна.



ГУРВАН КОМПАНИ “ОНЫ ШИЛДЭГ ЭНТРЕПРЕНЕР”-ЭЭР ШАЛГАРЛАА

МҮХАҮТ-аас Монгол Улсын нийгэм, эдийн засгийн хөгжилд бодитой хувь нэмэр оруулж буй шилдэг аж ахуйн нэгж, бизнес эрхлэгчдийг шалгаруулан, шилдгийн шилдгээр өргөмжилдөг “Энтрепренер” шалгаруулалтад М-Си-Эс Группийн гурван компани шилдгээр тодорлоо. МҮХАҮТ-ын Тэргүүлэгчдийн хурлын шийдвэрээр М-Си-Эс Кока-Кола ХХК болон Энержи Ресурс ХХК-ийн нийгэм, эдийн засагт оруулж буй хувь нэмрийг өндрөөр үнэлж, 2017 оны “Оны онцлох аж ахуйн нэгж”-ээр тодруулан мөнгөн Меркури гардуулж, М-Си-Эс Эстэйтс компанийг үл хөдлөх хөрөнгийн салбарын “Оны онцлох Энтрепренер”-ээр шалгаруулж, хүрэл Меркури гардуулан өргөмжиллөө.